

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Шаравын Лувсанцэдэв	Дугаар	L247
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Мандал-Овоо сум
Төрсөн газар	Манлай сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Тус хийдийн гэсгүй		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цохиотын хийд	Сүм хийдийн дугаар	ӨГМН 048
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 17	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга

Өмнөговь аймгийн Манлай сумын Цохиотын хийд

Гантулга: За та аль хийдэд шавилан сууж байсан бэ, өөрийгөө танилцуулна уу?

Лувсанцэдэв: За намайг Лувсанцэдэв гэдэг.Би найман настай Цохиотын хийдэд ламд шавь орж байж байсан.

Гантулга: Хэдэн жил шавилан суусан бэ?

Лувсанцэдэв: Аа тэнд ер нь яг суусан хугацаа хэлвэл ч цөөхөн сар байх.За үндсэндээ нэг жил болсон юм болов уу даа.

Гантулга:Танай хийдийн нэрийг юу гэдэг байсан бэ?

Лувсанцэдэв:Найман отчийн, Отчийн хурал гэдэг байсан.

Гантулга: Төвдөөр нэр байгаа болов уу?

Лувсанцэдэв: За мэдэхгүй байна аа.

Гантулга: Хэзээ ямар хүн байгуулсан хурал бол?

Лувсанцэдэв:Тэрнийг мэдэхгүй байна аа.

Гантулга: Хуучин захиргааныхаа юугаар бол аль аймгийн аль засаг хошуу гэж явдаг байсан бэ?

Лувсанцэдэв:Тэр хийд үү?

Гантулга: Тийм.

Лувсанцэдэв: Аа энэ л Өмнөговь амйгийн Засгийн хошуу гэдэг юм .Энэнд л багтаж байсан.

Гантулга: Энэ Цохиотын хурлын ойр орчимд байгаа гаазр усны нэрийг нэрлээч?

Лувсанцэдэв: За Цохиотын хийдийг тойрсон Уул гурван хараат гэж нэртэй газар тэр ерөөсөө.Хөгшин хайрхан гэж нэг уул байсан, овоо байдаг юм.Дундад гэж дундаа хайрхан, Хүүхэн хайрхан гэж ийм гурван овоо байдаг байсан байгаа юм даа. За тэр тусгай баруунтаа бол нэг хориод км Сүм суварга гэж байсан.

Гантулга: Хошуу ноёныг нь хэн гэдэг хүн байсан юм бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Лувсанцэдэв: Содномдорж гэдэг хүн байсан юм байна.

Гантулга: Ер нь одоо сүм хийдийн байгаа газрын байршил нь уул устай газар байсан уу, тэгш тал газар байсан уу?

Лувсанцэдэв: За тэрүүхэндээ бол манай эндхээр бол уул устай л газар байсан.Тийм худаг ус байхаас бол задгай ус гэж байхгүй.

Гантулга: Тахилгатай уулс ус, рашаан овоог нэрлэнэ үү?

Лувсанцэдэв:За тэр Дундад гэдэг овоог тахиж байсан, тэр Сүм суваргыг тахидаг байсан.

Гантулга: Ойр хавьд нь байсан сүм хийдийг нэрлэнэ үү?

Лувсанцэдэв: За тэр яг дэргэд нь галавын/галбын бололтой/ гурван хийдээс тасарсан Сахиусны сүм гэж нэг жаахан жижиг сүм байсан.

Гантулга: Цохиотын хийдийн гар зураг бий болов уу, одоо хийдийг зурсан тэг зураг?

Лувсанцэдэв: Байхгүй.

Гантулга: Та бол одоо цогчин дуганы л, цогчин дугандаа л шавилж сууж байсан үү?

Лувсанцэдэв: Тэгсэн.

Гантулга:Танай Цогчин дуганы чинь гол шүтээн нь ямар бурхан байсан бэ?

Лувсанцэдэв: За тэгээд л энэ Бурхан багшийн юунууд л байсан биз дээ.

Гантулга: Ядам сахиус нь?

Лувсанцэдэв: Заримыг нь ч одоо тэгээд л сайн мэдэхгүй байна.Мартчихаад байх юм.

Гантулга: Лхам бурхан гэж та түрүүн?

Лувсанцэдэв: Лхам бурхан гэдэг тусгай байжээ.

Гантулга: Гол шүтээн нь бол тийм бурхан гэж санахгүй байна уу, тийм ээ?

Лувсанцэдэв: Гол шүтээн нь бол Янсан...

Гантулга: Аа Янсан

Лувсанцэдэв: Байсан гэж байгаа юм.

Гантулга: Аа тэгээд л ядам, сахиусыг нь бол сайн санахгүй?

Лувсанцэдэв:Тийм.

Гантулга: Хэдэн ламтай хурал байсан бол?

Лувсанцэдэв: Жигжид, Жамсран энэ тэр гээд л сахиус байсан байх.Байсан л даа, дандаа тийм сахиуснууд тахидаг байсан.

Гантулга: Хэдий хэр ламтай хурал байсан бол?

Лувсанцэдэв: Нэг гуч, дөчөөд хүн байдаг байсан.

Гантулга: Хаанаас ирж ер нь лам нар шавилж суудаг байсан бэ, тэр нутаг хошуунаасаа юу, өөр газраас?

Лувсанцэдэв:Тэндээ байран суудаг лам цөөхөн байдаг байсан байх.Тэгээд өөрийнх нь лам нар хөдөө гэртэй , эд нар улирлаар ирж хурдаг байсан байх.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Нэртэй хутагт хувилгаадуудаас нь нэрлэвэл?

Лувсанцэдэв: За миний мэдэхийн тэрэн дээр нэг Намсрай хувилгаан л гэж байсан даа.

Гантулга: Өөр эрдэмтэй ,нэртэй том ?

Лувсанцэдэв: Уг нь энэ Манлай сумын л хүн юм гэнэ лээ.

Гантулга: Өөр одоо эрдэмтэй том лам нар, хэргэм зэрэгтэй?

Лувсанцэдэв: За тийм юм байгаагүй юм болов уу даа.

Гантулга: Энэ саяны хичнээн дүр хувилж яасан?

Лувсанцэдэв: Мэдэхгүй.

Гантулга: Тэрнийг нь бол мэдэхгүй, тийм хүний дүр энэ тэр гэж?

Лувсанцэдэв: Мэдэхгүй.

Гантулга: Гэлэн сахилтай хүн олон байсан болов уу?

Лувсанцэдэв: За бас нэг хориод хүн байсан байх.

Гантулга: Том эмч нар, зурхайч?

Лувсанцэдэв:Эмч хүн байсан, эм барьдаг хүн байсан.

Гантулга:Хэн гэж?

Лувсанцэдэв: Агаа үнзад гэж хүн байсан. Агаа л гэдэг...

Гантулга: Нэртэй уран хүмүүс, зураач?

Лувсанцэдэв: За тийм хүн байгаагүй юм болов уу даа.

Гантулга: Хийдийнх нь тэргүүн ламыг хамба лам гэдэг байсан уу, цорж, ловон үнзад, гэсгүй , даа ламыг нь нэрлэвэл?

Лувсанцэдэв:Ловон гэдэг байсан байх аа.

Гантулга: Унзад гэсгүй нь ямар улсууд байсан, цорж ловон? Тийм ловон, ийм цорж гээд?

Лувсанцэдэв: Рагчаа лам гэж байсан.Найдан ловон гэж лам байсан байгаа юм даа.Тэр ч одоо ловон гэх үү, хамба лам л хийх байх даа, Найдан гэдэг нь.Намжил гэж хүн байсан.За үнзад Агаа үнзад,Жигжид үнзад...Цэдэвдорж гэж үнзад байсан. Санжмятав гэж үнзад байсан, одоо өндөр Санжмятав.

Гантулга: Ийм ийм улсууд байдаг байсан уу?

Лувсанцэдэв:Тийм.

Гантулга: Дацан сургуулиуд байсан уу?

Лувсанцэдэв: Дацан сургууль байгаагүй. Лам нар нь л шавь нартай байсан.

Гантулга: Хичнээн дугантай, хичнээн суваргатай байсан хурал вэ?

Лувсанцэдэв: За байз, байж дээ.

Гантулга: Тийм тийм дуган гээд нэрлэвэл?

Лувсанцэдэв:Цогчин дуган, Дарь эхийн дуган, Хайлан дуган, Мамбан дуган, Тарвүү гэж бас байсан санагдаж байна.Тэгээд тэр Майдрын дугантай зургаа лав байж.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тарав гэж бас байж тийм ээ?

Лувсанцэдэв:Тэгж.

Гантулга:Ном барладаг үйлдвэр, бархан байсан уу?

Лвусанцэдэв:Байгаагүй байх аа, үгүй ээ мэдэхгүй л байна.Ер мэдэхгүй юм , ерөөсөө.Тэр тал руу нь ер нь яваагүй юм байна.

Гантулга: Цогчин дуган нь ямар уншлагатай байсан, энэ талаар бол? Ямар ном уншдаг байсан?

Лувсанцэдэв: За цогчингоо л уншдаг байсан байх даа.Маань хурдаг байсан, улирлын хурал чинь.Хайлан тэр хурал ер нь хайлан хурдаг байсан.Тэгээд өөр чинь одоо бас...

Гантулга: Зулын хорин таван?

Лувсанцэдэв: Зулын хорин тавнаар зулын хурал гэж хурдаг байсан.Тэр хуучны хурал гэж бас нэг сар хурдаг л байсан байх юм.Тэгээд л өнөө Лхам сахиус энэ тэрээ тахиадаг.

Гантулга: Тэгээд дүйчэн өдрүүдээр бас хуралтай, тийм ээ?

Лувсанцэдэв: Аа хурдаг л байсан.

Гантулга: Байнгын хуралтай байсан уу, зүгээр үе үе хурчихдаг байсан уу?

Лувсанцэдэв:Үгүй ээ тэр хурлуудын чөлөөнд байнгын бас байсан.Тэгээд л байнгын суурин ламтай , цогчин хуралтай л юм байж дээ.

Гантулга: Цамтай байсан болов уу?

Лувсанцэдэв:Аан?

Гантулга: Цам?

Лувсанцэдэв:Цамыг нь би үзээгүй , зүгээр...

Гантулга: Цам гардаг байсан болов уу?

Лувсанцэдэв: Аан үгүй.

Гантулга: Майдар эргэдэг байсан болов уу?

Лувсанцэдэв: Майдар эргэдэг байсан.

Гантулга: За лав л дөрвөн хүн, үгүй ээ зургаан хүн ч билүү, найман хүн байх аа. Хоёр хоёроороо дамнаад ингээд дөрвөлжин, тэр дотор нь өнөө бурхан нь байна, майдар бурхан нь байна.Тэгээд явдаг байсан.Тэгээд дөрвөн хүүхэд хойноосоо дагуулчихсан, майдар эргэнэ гээд л.Тэгээд л тэр майдринхаа сүмээс гараад л тэр гороогоо бүтэн эргээд л амраад л .Дөрвөн талд нь амралтан дээр нь дандаа ном зом уншаад л ингээд л явдаг байсан байх юм.Тэгж л эргэж байхыг би үзэж байсан.Нэг л удаа үзсэн.

Гантулга: Ганжуур эргэж байсан уу, хүрээгээр?

Лувсанцэдэв: За эргэж байсан байх .

Гантулга: Лам нар нь эргэж байсан уу, мөргөлчингүүд нь эргэж байсан уу?

Лувсанцэдэв: Мөргөлчингүүд эргэж байсан байгаа.

Гантулга: Хошууныхаа зэсээр ингэж, холуур тойрч энэтэр эргэж байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Лувсанцэдэв:Тэгсэн байх, тэгсэн гороо эргэнэ гээд.

Гантулга: Цагаан сараар ямар, өвлийн адаг сарын хэднээс хурдаг, ямар хурал хурдаг, сор залдаг байсан уу, ерөөл хэдийд нь хурдаг байсан бэ?

Лувсанцэдэв: За тэрийг чинь ер нь багахан хүн чинь сайн мэдэхгүй юм аа.Тэгээд өвлийн адаг сар л ер нь бүтэн хураастай л байдаг байсан.

Гантулга: Ерөөл?

Лувсанцэдэв: Тийм, битүүний шөнө чинь унтдаггүй л өглөө болгодог юм байсан.

Гантулга: Сор зална?

Лувсанцэдэв: Яамална, Лхам яамална л гэдэг байсан.Сор залж байсан.

Гантулга: Бурхан багшийн дүйчэн өдөр, Богд ламын дүйчэн өдрөөр ямар ямар ном хурдаг байсан?

Лувсанцэдэв:Тэрийг би чинь одоо мэдэхгүй юм.Одоо энэ уншдаг номнуудыг л уншиж байсан байх.Тэр үед одоо ер нь номынхоо юмыг сайн мэдэхгүй юмчинь.

Гантулга:Хайлантай байсан уу?

Лувсанцэдэв:Байсан.

Гантулга: Хэдэн лам хайланд суудаг байсан, гэлэн гэцэл голчилж суудаг байсан уу?

Лувсанцэдэв: Гэцэл сахилтай улсууд л, гэлэн гэцлүүд л байсан байх даа.

Гантулга: Аль сард, хэд хоног?

Лувсанцэдэв: Найман сард хурж байсан юм болов уу.

Гантулга: Олон хоног?

Лувсанцэдэв: За ер сайн мэдэхгүй л байна.

Гантулга:Нүгнээ сахидаг байсан юм болов уу?

Лувсанцэдэв: За ер нь сахидаг байсан гэж байгаа юм.Нүгнээн лам гэж байсан юм.Нүгнээн ламын байшин гэж одоо ч чухам туурь нь байж л байх юм билээ.

Гантулга: Том наадам хийдэг, том шашны баяр хийж байсан болов уу?

Лувсанцэдэв:Үгүй ээ тэр овоо тахиж наадам хийж л байсан даа:Тэр Сүм суварганы овоог тахихад наадам хийж байсан.

Гантулга: Цогчин дуганд одоо өдөр бүрийн хурал, сар бүрийн хурал , жилийн хурлаас өөр ямар зан үйл хийж байсан бэ? Шашны ёслол?

Лувсанцэдэв: Аа сайн мэдэхгүй юм.

Гантулга: Модоор уу, тоосгоор уу, зөнгөөр үү?

Лувсанцэдэв: Аа зөнгөөр.

Гантулга: Зөнгөөр?

Лувсанцэдэв: Зөнгөөр л барьсан.

Гантулга: Ямар оройтой байсан? Сүмэн оройтой юу, тэгшхэн дөрвөлжин?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Лувсанцэдэв: Дөрвөлжин оройтой сүм нэг л байсан. Бусад нь дандаа юу оройтой, нөгөө асар данзан гэдэг билүү, тийм л сүмүүд байсан байх юм.

Гантулга: Дөрвөлжиндүү, голчилж дөрвөлжин байсан уу, дугуй гэр сүм байгаагүй юу?

Лувсанцэдэв: Байгаагүй. Дандаа дөрвөлжин л байсан.

Гантулга: Дацан сургуулиуд бол байгаагүй юу?

Лувсанцэдэв: Байгаагүй байх аа.

Гантулга: Өөр одоо ойролцоох сүм хийдүүдтэй ямар харилцаа холбоотой байсан, лам нар нь ирж очих, ном хаялцдаг, том хуралд нь ирж суудаг ч гэдэг юм уу?

Лувсанцэдэв: Энэ Шүтээнтэй л хобоотой байсан байх. Өлгий, Шүтээнтэй л холбоотой байсан байх.

Гантулга: Өлгий хуралтай?

Лувсанцэдэв: Тийм.

Гантулга: Төвд, Энэтхэгийн хийдүүдтэй харилцаа холбоо?

Лувсанцэдэв: Мэдэхгүй.

Гантулга: Олон жастай байсан болов уу?

Лувсанцэдэв: Урагшаа тэр Галавын гурван хийд гээд тэрэнтэй холбоотой байсан байх. Гамбантай холбоотой байсан байх.

Гантулга: Жас, олон жастай байсан уу?

Лувсанцэдэв: Аа бас Дарь эхийн жас, Мамбан жас, Хайлан жас, Цогчин жас гээд тав л лав байсан байх юм.

Гантулга: Жас нь баян мал тоо толгой олон байсан уу?

Лувсанцэдэв: Аа малтай байсан юм гэнэ лээ. Жасын мал малладаг айлууд гээд байдаг байсан юм.

Гантулга: Хошуу нутагтаа татвар энэ тэр төлдөг байсан юм болов уу?

Лувсанцэдэв: Мэдэхгүй юм аа.

Гантулга: Лам нар хийд дээрээ аймаглан суудаг байсан уу, эсвэл тусгайлан хороолол маягаар хийдээ тойроод байрладаг байсан уу?

Лувсанцэдэв: Тараад байрладаг байсан байх.

Гантулга: Цөөхөн ламтай байсан уу?

Лувсанцэдэв: Тийм.

Гантулга: Хийдэд зоч лүйжинч улсууд байдаг байсан уу, эсвэл гаднаас зоч лүйжинч улсууд хийдээ тойроод байрладаг байсан уу?

Лувсанцэдэв: Үгүй ээ, тийм юм байсныг нь би мэдэхгүй, үгүй л юм шиг байна.

Гантулга: Тэрийг бол сайн мэдэхгүй байна уу?

Лувсанцэдэв: Үгүй байна. Зоч лам гээд ярьдаг л байсан. Тэр зурхайч зоч гээд ярихаар тэр зурхайч, энэ зурхайч гээд л ...

Гантулга: Тэгэхээр байж тийм ээ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Лувсанцэдэв: Байсан юм аа. Тэр зурхайч, энэ зоч гээд л ярьдаг байсан.

Гантулга: Та одоо өглөө босоод орой унтах хүртлээ юу хийдэг байсан, лам хүнийхээ нэг өдрийн амьдралыг ярьж өгөөч?

Лувсанцэдэв: Тэнд байхдаа юу?

Гантулга: Тийм, хүрээн дээр шавилж сууж байхдаа?

Лувсанцэдэв: Аа тэнд байхдаа бол яахав дээ, өглөө босоод манз цаваа, багшийндаа байж байхдаа манз цавыг нь барина даа.Тэгээд л өнөө жас сүм хоёрын хооронд чинь домбоо бариад л гүйгээд байдаг байсан байна шүү дээ./инээв/

Гантулга: Тэгээд номоо хэзээ шүүлгэх вэ, хуралд хэзээ суух уу?

Лувсанцэдэв:Хуралд яахав дээ, өнөө ном мэдэхгүй хүүхэд чинь юугаа ч нэг их уншдаг байхав дээ.Манж л хурдаг байсан байх.Багшаар өнөө хэдн юм хэлүүлж аваад л тэрийгээ цээжлэх гээд л гэртээ суудаг л , тийм л байсан байгаа юм.

Гантулга:Тэгээд л орой болгод л өглөө нь дахиад л давтаад л ?

Лувсанцэдэв:Тийм.

Гантулга: Хийдийн ойролцоо одоо зүгээр энэ хар улсууд байсан болов уу?

Лувсанцэдэв: Байлгүй дээ.

Гантулга: Өөр ажил эрхэлдэг, туслах , малчин?

Лувсанцэдэв: За байсан байх аа, тэрийг чинь одоо санахгүй л байна.

Гантулга: Мөргөлчид их ирж хийд дээр байрладаг байсан болов уу? Байран, суурин?

Лувсанцэдэв: Аа байдаг байсан, тэр чинь эм барьдаг хүнтэй.

Гантулга: Эмнүүлэх гэж?

Лувсанцэдэв:Эмнүүлдэг барьдаг улсууд тэгээд мөргөлчид, эмчлүүлэх улсууд ч ирдэг, мөргөлчин улсууд ч очдог л байсан байх.

Гантулга: Ойролцоо одоо худалдаа наймаа, зах зээлийн газар байсан болов уу?

Лувсанцэдэв: Байгаагүй байх аа.

Гантулга:Хятад наймаа гэж ирж байсан болов уу?

Лувсанцэдэв: За миний мэдэх ч юм үгүй л байна.Ер нь бол ирдэг л байсан юм гэнэ лээ.

Гантулга: Сонссон нь?

Лувсанцэдэв: Сонссон.

Гантулга: Та хэзээ хэдэн онд шавилахаа больсон бэ?

Лувсанцэдэв: Үгүй ээ би чинь ер нь ...за байз гучин нэгэн онд гарсан байдаг юм болов уу.Тэгээд л гарсан даа, тэрнээс маргаауш нь нөгөөдөр нь ч билүү сураг дуулаад л, манай эцэг өвгөн очоод намааг сундлаад буцаж байсан юм байгаа. Тэрнээс хойш ахиж очоогүй.

Гантулга: Тэр лам нарыг яасан тухай нь та дуулсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Лувсанцэдэв: Би дуулсан, дан хувьсгалын эсэргүү нарыг барьсан л гэж...

Гантулга: Тэгээд цаазаар?

Лувсанцэдэв: Тэгэлгүй, сураггүй л болцгоосон.

Гантулга: Тэгээд тэр Цохиотын хийдийг тэр дор нь хүн ирээд нураачихсан уу?

Лувсанцэдэв: Аа сүүлд нь , нэлээн сүүлд л нураасан дуулдсан.

Гантулга: Бурхан шүтээн, ном судрыг нь?

Лувсанцэдэв: Түлсэн юм дуулдсан.

Гантулга: Түлээд?

Лувсанцэдэв: Овоолж байгаад түлж байна л гэж дуулдсан.

Гантулга: Тэндээс авч нууж үлдсэн юм бол байхгүй?

Лувсанцэдэв: Байхгүй байх аа, тийм овсгоотой хүн байгаагүй юм аа ер нь бол.

Гантулга: Тэгээд л дараа нь та малчин болоод л?

Лувсанцэдэв: Байсан ч одоо дуулаагүй, хэлээгүй болвол ямар юмаа дуулахав. Тэгээд одоо мэдэхгүй.

Гантулга: Дараагаар нь мал маллаж байгаад цэрэгт явсан уу?

Лувсанцэдэв: Тэгсэн.

Гантулга: Ер нь цуг сууж байсан банди нар, арай ахмад улсуудтайгаа сүүлд нь холбоо харилцаатай байж энэ хурал номынхоо үйл ажиллагааг хувиараа эрхэлж байсан болов уу?

Лувсанцэдэв: Огт үгүй.

Гантулга: Хэзээ эргэж лам болсон бэ?

Лувсанцэдэв: Лам болох ч юу байхав дээ.Энэ хийдийг барьсан хойно нь л би энэ дээр ирсэн юм.Одоо энэ хүүхэд шуухад харах ажилтай тэгээд...

Гантулга: Хийд хэзээ сэргээгдсэн бэ? Суман дээр?

Лувсанцэдэв: Энэ чинь одоо хэдэн жил юм бэ дээ, дөрөв таван жил болж байна уу.

Гантулга: Тэгээд л та лам болчихсон юм байна , тийм ээ?

Лувсанцэдэв: Тийм.

Гантулга: Тэрнээс өмнө бол тэр хийд байгуулагдахаас өмнө бол?

Лувсанцэдэв: Үгүй.

Гантулга: Сахил махил аваагүй?

Лувсанцэдэв: Үгүй ээ үгүй, тэгэхэд чинь би одоо...